



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот

Захиалагчийн хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын үргэлжлэл ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, уг төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

2.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 2,607.7 (хоёр тэрбум зургаан зуун долоон сая долоон зуун мянга) сая төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “24.1.15”-ын “13”-т заасан “Гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл, барилга угсралтын ажил (Улаанбаатар хот)”-ын хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (М.Баяраа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020001607

Нийслэлийн Засаг даргын 2022 оны
 03 дугаар сарын 04 ны өдрийн
 А/245 дугаар захирамжийн
 хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
 ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕРИЙН
 ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГА
 УГСРАЛТЫН ҮРГЭЛЖЛЭЛ АЖЛЫН ЖАГСААЛТ**

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	(сая төг) 2022 онд санхүүжих дүн
1	14 дүгээр хорооллын цахилгааны 110/35/10кв-ын дэд станцын гаргалгаа 4 иж бүрдэл, 10кв-ын хаалттай хуваарилах байгууламж 3 иж бүрдэл, 10кв-ын хаалттай дэд өртөө 12 иж бүрдэл, 10кв-ын 18.4км кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын ажлын үргэлжлэл	2022	1,500.0
2	Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах "Түмэн Амгалан" орон сууцны хорооллын гадна инженерийн хангамжийн ажлын үргэлжлэл	2022	500.0
3	Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр Орон сууцны 14 хороолол "А" хэсэгчилсэн талбайн цахилгааны 2*1000кВА хүчин чадалтай 5 ком ХТП-ийн зураг төсөл, барилга угсралтын ажил	2022	607.7
ДҮН			2,607.7